



## БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/59/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: Утас: 88011833 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Азбаяр Утас: 99061429 Цахим хаяг: Azbayarb@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

Аудитын гэрчилгээ .....	3
Аудитын тайлан .....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.13. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
Менежментийн захидал.....	11
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18

Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Б А Я Н Х О Н Г О Р С У М Ы Н Э Р Д Э М А Х Л А Х  
С У Р Г У У Л И Й Н ЗАХИРАЛ Ц.ЗАГДСҮМ  
ТАНАА

So. No. Od. 14 № 1/84

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Аудитын гэрчилгээ 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020040


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

## Аудитын тайлан

### 2.1. Оршил

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Ц.Загдсүм танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.01-аас 2020.02.03-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургууль нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-т 2020.01.25-ний өдрийн № 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Суралцагчдад сурч боловсрох, авьяас чадвараа нээн хөгжүүлэх, амьдрах арга ухаанд суралцах сонирхол хэрэгцээнд нь нийцсэн, сургалт хүмүүжлийн ажлын уялдаа холбоог нягтруулан, хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг эрчимжүүлж, ардчилсан, хүмүүнлэг үйлчилгээг үзүүлэх.” гэсэн эрхэм зорилго оршино.

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Эх хэл, өв уламжлалаа дээдэлсэн, эвийг эрхэмлэгч, эерэг хандлагатай, эрүүл бие зөв дадалтай, ирээдүйд эзэмших мэргэжлийн чиг баримжаагаа зөв тодорхойлсон хамт олон болно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous” программ хангамж ашиглаж байна.

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 28 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 28 асуудал нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1729142,7 мянган төгрөгөөс тооцон 34582,9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 34582,9 мянган төгрөгөөр тооцсон нь үр дүнгийн тайлангийн зардлыг суурь болгон сонгосонтой холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 57470,7 мянган төгрөгөөр буюу 2,3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	2,101.2	-	(2,101.2)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	73,412.3	67,903.7	(5,508.6)
Үндсэн хөрөнгө	2,374,206.8	2,324,345.8	(49,861.0)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,449,720.2</b>	<b>2,392,249.5</b>	<b>(57,470.7)</b>
Өр төлбөр	150.2	659.1	508.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,449,570.0	2,391,590.4	(57,979.6)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,449,720.2</b>	<b>2,392,249.5</b>	<b>(57,470.7)</b>

Авлага дансны үлдэгдэл 2101,2 мянган төгрөгөөр буурсан бөгөөд энэ нь НДШ 1677.1 мянга, ХХОАТ 424,1 мянган төгрөгийг тайлант онд суутган тооцож барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 5508,6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх аудитын зөвлөмжийн дагуу ашиглах боломжгүй болсон 37822,1 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгасан ба харин үнэ төлбөргүй 16559,3 мянган төгрөгийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 49861,0 мянган төгрөгөөр буурсан бөгөөд тайлант онд 45327,0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж тайлант онд 93036,3 мянган төгрөгийн элэгдлийн зардал гарсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 508,9 мянган төгрөгөөр өссөн нь үдийн цайны гүйцэтгэгч "Тосуйн гол" ХХК -д 239,2 мянга иргэн Б.Мөнхжаргалд барилгын засварын материалын үлдэгдэл 129,0 мянган төгрөгийн өглөгтэй гарсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2391590,4 мянган төгрөг болж 57979,6 мянган төгрөгөөр буурсан нь тайлан үеийн үр дүн байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Баянхонгор сумын Эрдэм ахлах сургууль нь тайлант онд өөрийн орлого төлөвлөөгүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 1603737,2 мянган төгрөгийн төсөв урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Тайлант онд нийт 1603737,2 сая төгрөгийн төсөв батлагдсаны 1393311,6 мянган төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлгээр 210425,6 мянган төгрөгийг авахаар батлагдсан ба гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч оны эцэст 3849,4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1599,9 сая төгрөг буюу 99,8 хувьтай байгаагаас гол хэмнэгдсэн зардал нь цалингийн зардал 1,3 сая, ЭМНДШ-ийн зардал 2,2 сая төгрөг хэмнэгдсэнээс шалтгаалсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 3 багшийн Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны 12296,4 мянган төгрөгийн тэтгэмж санхүүжилтээр ирж зориулалтын дагуу зарцуулсан байна. Мөн түрээсийн сурах бичгийн 3180,4 мянган төгрөгийг төвлөрүүлэн БСШУЯ-нд шилжүүлсэн, 2160,8 мянган төгрөгийн түрээсийн орлого орж, шүдний лабораторийн тоног төхөөрөмж, материалыг авсан байна.

#### 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 28 эрсдэл тодорхойлж нийт 28 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 905,2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 186,6 мянган төгрөгийн алдаанд залруулга хийж, 718,6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал  
(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	5634,9	
2	Төлбөрийн акт	1	816,5	
	Дүн	3	6451,4	

Аудитаар дараах 6451,4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа илэрсэнд төлбөрийн акт тогтоож, зөвлөмж хүргүүллээ. Үүнд:

1. "Тосуйн гол" ХХК-тай сургуулийн гал тогоо болон түүний тоног төхөөрөмжийг ашиглах гэрээг байгуулсан бөгөөд гүйцэтгэлээр 2374,7 мянга төгрөг авахаар байхад гүйцэтгэлээр 2160,8 мянган төгрөг авч 213,9 мянган төгрөг дутуу төвлөрүүлсэн. Мөн тухайн компани нь 2019 оны 2,9 дүгээр сарын цахилгааны төлбөр 257,8 мянган төгрөгийг төсвөөс төлсөн.

Энэ нь "Тосуйн гол" ХХК-тай хийсэн гэрээний 3 дугаар зүйлийн 3.3-т "Түрээслүүлэгч, түрээслэгч нь түрээсийн төлбөр төлөх хуваарийг харилцан тохиролцож сар бүрийн 27-ны дотор төлнө", 3.6-д "Гал тогооны цахилгааны үнийг тоолуурын заалтын дагуу тооцож сар бүрийн 28-ны дотор түрээслэгч байгууллагын дансанд төвлөрүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй, "эрх үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

2. Цалингийн зардлаас 65,4 мянган төгрөгийн өглөгтэй байхаар тооцоо гарч байхад татварын мэдээг дутуу мэдээлснээс 123,3 илүү төлөлттэй гарч 188,7 мянган төгрөгийн татварын орлого дутуу төлсөн. Мөн ЭМНДШ-д 650,0 мянган төгрөгийн цалинг илүү мэдээлж, түүнд ногдох 156,1 мянган төгрөгийн шимтгэл илүү төлсөн.

Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 17.1-д заасан "Цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогод албан татвар ногдуулах орлогыг дараах байдлаар тодорхойлно", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17-р зүйлийн 17.1.1-д заасан "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалттай нийцэхгүй, "үнэн зөв" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

3. Цалингийн зардлыг 3924,9 мянган төгрөгөөр ажил олгогчоос төлөх НДШ-ээс гүйлгэн зарцуулсан.

Энэ нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-ын хавсралт 6-ийн "цалин, хөлс болон нэмэгдэл урамшил", "Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл" гэсэн заалттай нийцэхгүй, "хэмжилт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх.

4. Барилгын засварын материал дансаар 917.0 мянга, Бусад хангамжийн материалаар 648,4, Бичиг хэрэг 140.4 мянга, аж ахуйн материал 9,0 мянган төгрөгөөр эд хариуцагчийн тайланг илүү гаргасан нь өмнөх сарын тайланд туссан материалыг дахин давхардуулан гаргасан байгаа нь эд хариуцагчийн тайланд тавих хяналт сул байгаатай холбоотой байна. Дээрх зөрчлийг аудитын явцад залруулав.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т заасан "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалттай нийцэхгүй, "үнэн зөв" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх.

## 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй.

## 2.13. Шилэн дансны мэдээлэл

Тайлант хугацаанд байршуулбал зохих 151 мэдээллээс 37 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан 5 мэдээллийг илгээгээгүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй
1	Бүтэн жил	11	11	7	1	3
2	Хагас жил	4	4	3	0	1
3	Улирал бүр	1	4	2	1	1
4	Сар бүр	3	36	29	7	0
5	Тухай бүр	8	96	68	28	0
6	Нийт	27	151	109	37	5

#### **2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1896,5 мянган төгрөгийн 2 төрлийн зөрчилд төлбөрийн акт тогтоосныг бүрэн төвлөрүүлсэн бөгөөд 3 заалт бүхий зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан бөгөөд хэрэгжилтийг тус байгууллагын 2019.05.01-ний өдрийн 87 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1. Зардлын данстай холбоотой

##### 1.1. Илрүүлэлт:

Цалингийн зардлыг 3924,9 мянган төгрөгөөр ажил олгогчоос төлөх НДШ-ээс гүйлгэн зарцуулсан.

##### 1.2. Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй.

##### 1.3. Өгсөн зөвлөмж:

Зардлыг хуульд заасан хувь хэмжээг харгалзан үзэж бодитой төлөвлөн зардал гаргахдаа Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-ыг мөрдөж ажиллах.

#### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

##### 2.1. Илрүүлэлт:

Бараа материалын дансны үлдэгдэл, тооллогын бүртгэлтэй тохирч байна. Барилгын засварын материал дансаар 917.0 мянга, Бусад хангамжийн материалаар 648,4, аж ахуйн материалаар 9,0 мянган төгрөгийг эд хариуцагч орлого авч зарлага гаргасан байхад нягтлан бодогч орхигдуулж шууд зардлаар бүртгэсэн. Бичиг хэргийн дансаар 140.4 мянган төгрөгийг эд хариуцагч орлогоор бүртгээгүй.

**2.2. Эрсдэл:**

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй.

**2.3. Өгсөн зөвлөмж:**

Эд хариуцагчийн тайланг цаг тухай бүрд нь нягтлан шалгаж, бүртгэл тайлан хөтөлж байх, анхан шатны баримтгүй ажил гүйлгээг тайланд тусгадаг явдлыг таслан зогсоох.

**2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>75,513,462.69</b>	<b>67,903,682.83</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,101,175.86	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	2,101,175.86	00.00
3351	Байгууллагаас авах авлага	2,101,175.86	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	73,412,286.83	67,903,682.83
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	37,124,349.83	46,036,209.83
35110	Тусгай зориулалттай материал	37,124,349.83	42,430,409.83
35130	Эм боох материал	00.00	3,605,800.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	36,287,937.00	21,867,473.00
35410	Бичиг хэргийн материал	1,633,250.00	635,000.00
35420	Аж ахуйн материал	3,615,809.00	1,131,809.00
35450	Барилгын засварын материал	120,500.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	30,918,378.00	20,100,664.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,374,206,750.67</b>	<b>2,324,345,816.49</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,374,206,750.67	2,324,345,816.49
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,005,956,750.67	1,956,095,816.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,878,063,070.24	1,907,563,070.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	-9,083,590.68	-49,744,508.28
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	259,883,674.90	260,482,738.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	-191,954,396.76	-213,479,268.30
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	170,865,198.35	158,707,761.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	-105,151,508.67	-109,154,959.71
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	194,732.56	194,732.56
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,259,486.00	20,259,486.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-17,119,915.27	-18,733,236.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	368,250,000.00	368,250,000.00
39301	Програм хангамж	1,919,860.00	1,919,860.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,919,860.00	-1,919,860.00
39303	Бусад биет бус хөрөнгө	368,250,000.00	368,250,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,449,720,213.36</b>	<b>2,392,249,499.32</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>150,180.00</b>	<b>659,080.26</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	150,180.00	659,080.26
<b>413</b>	<b>Өглөг</b>	150,180.00	659,080.26
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	278,480.26
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	150,180.00	380,600.00
41361	Байгууллагад төлөх өглөг	12,400.00	251,600.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	137,780.00	129,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,449,570,033.36</b>	<b>2,391,590,419.06</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,449,570,033.36	2,391,590,419.06
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,627,034,865.06	1,627,034,865.06
51101	Өмч: - төрийн	1,627,034,865.06	1,627,034,865.06
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-77,478,771.48	-135,458,385.78
51210	Өмнөх үеийн үр дүн	-77,478,771.48	-77,478,771.48
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-57,979,614.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	900,013,939.78	900,013,939.78
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,449,720,213.36</b>	<b>2,392,249,499.32</b>

#### 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>763,743,960.00</b>	<b>1,671,163,060.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,964,002.00</b>	<b>54,073,460.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,964,002.00	54,073,460.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,964,002.00	54,073,460.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,014,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	5,341,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,950,002.00	48,732,260.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>16,696,258.00</b>	<b>223,778,000.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	742,083,700.00	1,393,311,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>12,320,000.00</b>	<b>13,352,400.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,320,000.00	13,352,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>00.00</b>	<b>210,425,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	210,425,600.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>4,376,258.00</b>	<b>00.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	4,376,258.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>752,757,101.39</b>	<b>1,729,142,674.30</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>752,757,101.39</b>	<b>1,729,142,674.30</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>744,271,301.39</b>	<b>1,652,933,873.30</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>511,538,680.31</b>	<b>1,116,117,513.12</b>
210101	Үндсэн цалин	413,772,283.00	915,580,114.12
210102	Нэмэгдэл	65,840,300.00	117,993,048.00
210104	Урамшуулал	31,926,097.31	82,544,351.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>62,759,942.49</b>	<b>134,434,621.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	62,759,942.49	103,304,321.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	7,782,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	6,225,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	1,556,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	15,565,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>113,184,625.00</b>	<b>203,825,713.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,004,887.00	7,365,257.00
210302	Түлш, халаалт	97,938,600.00	173,919,400.00
210303	Цэвэр, бохир ус	11,241,138.00	22,541,056.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,794,890.01</b>	<b>23,115,682.00</b>
210401	Бичиг хэрэг	798,300.00	9,750,290.00
210402	Тээвэр, шатахуун	824,010.01	1,848,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,127,580.00	3,333,468.00
210404	Ном, хэвлэл	45,000.00	90,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	7,913,924.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>40,000.00</b>	<b>5,542,500.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,000.00	1,880,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	3,662,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,390,500.00</b>	<b>15,708,652.03</b>
210602	Тавилга	00.00	2,151,652.03
210604	Урсгал засвар	2,390,500.00	13,557,000.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>00.00</b>	<b>2,829,000.00</b>

**Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210702	Дотоод албан томилолт	00.00	2,829,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,562,620.00</b>	<b>9,449,200.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,562,620.00	8,849,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	600,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>40,000,043.58</b>	<b>141,910,992.15</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,000.00	5,427,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	180,000.00	43,446,910.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,780,043.58	93,036,282.15
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,485,800.00</b>	<b>76,208,801.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>8,485,800.00</b>	<b>72,359,400.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,485,800.00	58,782,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	12,296,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,281,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>100,627.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	100,627.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>3,748,774.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,748,774.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>10,986,858.61</b>	<b>-57,979,614.30</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>10,986,858.61</b>	<b>-57,979,614.30</b>

#### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,316,509,734.40</b>	<b>1,622,430,800.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,137,980.00</b>	<b>5,341,200.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,137,980.00</b>	<b>5,341,200.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,137,980.00	5,341,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,624,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	513,980.00	5,341,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,314,371,754.40</b>	<b>1,617,089,600.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,276,993,000.00	1,393,311,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>22,948,750.40</b>	<b>13,352,400.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,948,750.40	13,352,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>00.00</b>	<b>210,425,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	210,425,600.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>14,430,004.00</b>	<b>00.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	14,430,004.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,316,509,734.40</b>	<b>1,622,430,800.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,316,509,734.40</b>	<b>1,622,430,800.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,214,164,899.00</b>	<b>1,546,461,199.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>849,001,126.00</b>	<b>1,113,737,857.00</b>
210101	Үндсэн цалин	716,601,026.00	912,302,057.00
210102	Нэмэгдэл	87,787,000.00	117,993,048.00

Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210104	Урамшуулал	44,613,100.00	83,442,752.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	114,573,100.00	134,434,621.00
210201	Тэтгэврийн даатгал	81,214,100.00	95,196,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,339,400.00	9,630,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,671,900.00	7,587,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,667,900.00	1,896,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,679,800.00	20,123,921.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	202,526,762.00	203,825,713.00
210301	Гэрэл, цахилгаан	6,965,996.00	7,365,257.00
210302	Түлш, халаалт	174,066,400.00	173,919,400.00
210303	Цэвэр, бохир ус	21,494,366.00	22,541,056.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,906,061.00	17,756,858.00
210401	Бичиг хэрэг	2,517,470.00	7,533,870.00
210402	Тээвэр, шатахуун	1,648,000.00	1,848,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,173,371.00	3,333,468.00
210404	Ном, хэвлэл	385,000.00	1,841,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,182,220.00	3,019,820.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	347,000.00	1,758,050.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	347,000.00	1,410,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	348,050.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,788,500.00	37,159,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	21,007,800.00
210602	Тавилга	00.00	149,000.00
210604	Урсгал засвар	3,788,500.00	16,002,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	782,700.00	2,829,000.00
210702	Дотоод албан томилолт	782,700.00	2,829,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	22,287,750.00	9,619,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,287,750.00	9,019,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	600,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	12,951,900.00	25,340,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,291,900.00	7,992,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,660,000.00	17,348,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>102,344,835.40</b>	<b>75,969,601.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	101,385,554.00	72,120,200.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	14,430,004.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	60,374,950.00	58,542,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	26,130,600.00	12,296,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	450,000.00	1,281,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	941,281.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	941,281.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	18,000.40	100,627.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,000.40	100,627.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	3,748,774.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,748,774.00
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,258,784,865.06	00.00	-2,292,348.49	00.00	1,256,492,516.57
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,258,784,865.06</b>	<b>00.00</b>	<b>-2,292,348.49</b>	<b>00.00</b>	1,256,492,516.57
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	368,250,000.00	00.00	10,986,858.61	00.00	379,236,858.61
C08	<b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,627,034,865.06</b>	<b>900,013,939.78</b>	<b>-77,478,771.48</b>	<b>00.00</b>	2,449,570,033.36
D01	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,627,034,865.06</b>	<b>900,013,939.78</b>	<b>-77,478,771.48</b>	<b>00.00</b>	2,449,570,033.36
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,627,034,865.06</b>	<b>900,013,939.78</b>	<b>-77,478,771.48</b>	<b>00.00</b>	2,449,570,033.36
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-57,979,614.30	00.00	-57,979,614.30
D09	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,627,034,865.06</b>	<b>900,013,939.78</b>	<b>-135,458,385.78</b>	<b>00.00</b>	2,391,590,419.06

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,278,617,000.00	1,277,675,719.00	1,603,737,200.00	1,599,887,799.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,278,617,000.00	1,277,675,719.00	1,603,737,200.00	1,599,887,799.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,191,022,700.00	1,190,720,169.00	1,543,905,200.00	1,540,063,999.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	848,647,200.00	848,647,146.00	1,115,013,100.00	1,113,737,857.00
210101	Үндсэн цалин	716,247,100.00	716,247,046.00	909,989,900.00	912,302,057.00
210102	Нэмэгдэл	87,787,000.00	87,787,000.00	118,115,300.00	117,993,048.00
210104	Урамшуулал	44,613,100.00	44,613,100.00	86,907,900.00	83,442,752.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	114,573,200.00	114,573,100.00	136,615,800.00	134,434,621.00
210201	Тэтгэврийн даатгал	114,573,200.00	114,573,100.00	136,615,800.00	95,196,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	00.00	9,630,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	00.00	7,587,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	00.00	1,896,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	00.00	20,123,921.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	202,526,800.00	202,526,762.00	203,925,600.00	203,825,713.00
210301	Гэрэл, цахилгаан	7,104,200.00	6,965,996.00	7,105,200.00	7,365,257.00
210302	Түлш, халаалт	174,006,400.00	174,066,400.00	174,006,400.00	173,919,400.00
210303	Цэвэр, бохир ус	21,416,200.00	21,494,366.00	22,814,000.00	22,541,056.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,043,100.00	7,906,061.00	17,757,000.00	17,756,858.00
210401	Бичиг хэрэг	3,152,300.00	2,517,470.00	4,214,000.00	7,533,870.00
210402	Тээвэр, шатахуун	1,648,000.00	1,648,000.00	1,848,000.00	1,848,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,000,800.00	2,173,371.00	3,840,000.00	3,333,468.00
210404	Ном, хэвлэл	1,258,300.00	385,000.00	5,185,000.00	1,841,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00	180,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	983,700.00	1,182,220.00	2,490,000.00	3,019,820.00
2105	<b>Нормативт зардал</b>	468,300.00	347,000.00	1,868,700.00	1,758,050.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	165,600.00	347,000.00	1,410,000.00	1,410,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	302,700.00	00.00	458,700.00	348,050.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,788,900.00	3,788,500.00	37,164,500.00	37,159,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	00.00	6,264,500.00	21,007,800.00
210602	Тавилга	00.00	00.00	20,000,000.00	149,000.00
210604	Урсгал засвар	3,788,900.00	3,788,500.00	10,900,000.00	16,002,200.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	783,600.00	782,700.00	2,983,300.00	2,829,000.00
210702	Дотоод албан томилолт	783,600.00	782,700.00	2,983,300.00	2,829,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	712,100.00	677,000.00	3,222,600.00	3,222,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	712,100.00	677,000.00	2,622,600.00	2,622,000.00

**Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

	үйлчилгээний төлбөр хураамж				
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	600,000.00	600,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	11479500.00	11471900.00	25354600.00	25340900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,979,500.00	5,971,900.00	8,000,000.00	7,992,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,500,000.00	5,500,000.00	17,354,600.00	17,348,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	87594300.00	86955550.00	59832000.00	59823800.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	87594300.00	86955550.00	59,832,000.00	59,823,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	60,954,400.00	60,374,950.00	58,542,800.00	58,542,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	26,130,600.00	26,130,600.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	509,300.00	450,000.00	1,289,200.00	1,281,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,278,617,000.00	1,277,675,719.00	1,603,737,200.00	1,599,887,799.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,276,993,000.00	1,276,051,719.00	1,393,311,600.00	1,389,562,826.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,276,993,000.00	1,276,051,719.00	1,393,311,600.00	1,389,562,826.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,624,000.00	1,624,000.00	210,425,600.00	210,324,973.00
132001	Орон нутгийн төсвөөс	1,624,000.00	1,624,000.00	210,425,600.00	210,324,973.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	00.00	00.00	01.00	01.00
610001	Төсвийн байгууллага	00.00	00.00	01.00	01.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	100.00	99.00	100.00	99.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	72.00	71.00	72.00	71.00
620003	Үйлчлэх ажилтан	27.00	27.00	27.00	27.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	1,414.00	1,359.00	1,414.00	1,359.00
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	00.00	00.00	1,414.00	1,359.00
630001	Төрийн өмчит ЕБС	1,414.00	1,359.00	1,414.00	1,359.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	100.00	99.00	100.00	99.00
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	79.00	78.00	79.00	78.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	21.00	21.00	21.00	21.00

**4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэлийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	23462730.40	18693600.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	23462730.40	18693600.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	23462730.40	18693600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	23462730.40	18693600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	513980.00	5341200.00

**Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22948750.40	13352400.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>23462730.40</b>	<b>18693600.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>23462730.40</b>	<b>18693600.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	<b>513980.00</b>	<b>5341200.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22948750.40	13352400.00

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

**БЭЛТГЭСЭН:**

**АХЛАХ АУДИТОР:**



**Б.АЗБАЯР 2020.02.14**

**АНХАН ШАТАНД ХЯНАСАН:**


**АУДИТЫН МЕНЕЖЕР:**



**А.ЦЭЭНЯМ 2020.02.14**

**ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:**

**ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:**



**Б.МӨНХБАТ 2020.02.14**